



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А1150

Улаанбаатар хот


Мод үржүүлгийн газар байгуулах ажилд
хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16.5.5, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3 дугаар бүлгийн 3.6, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотыг дэлхийн ногоон хотуудын жишгээр хөгжүүлэх зорилтын хүрээнд нийслэлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд хэрэглэгдэх мод, сөөгний суулгацаар хангах үүрэгтэй мод үржүүлгийн газрыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын дэргэд байгуулах, хашаа, худаг, хүлэмж барих, мод, сөөгний тарьц, суулгац үржүүлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, хамтран ажиллах гэрээ байгуулах, хийгдэх ажлын төлөвлөгөө, графикыг гаргах, мод үржүүлгийн газар байгуулах ажлын явц, үр дүнг тайлагнаж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

2. Мод үржүүлгийн газарт хийгдэж байгаа ажлын явц, үр дүнг сар бүр тайлагнаж ажиллахыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ /Б.Бямбадорж/-т даалгасугай.

3. Мод үржүүлгийн газрын материаллаг баазыг сайжруулах, мод, сөөгний тарьц, суулгац үржүүлэх ажилд шаардагдах 50.000.000 /Тавин сая/ төгрөгийг Ногоон байгууламжийн арчилгааны зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

